



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

LUXEMBOURG  
AID & DEVELOPMENT



# ЖИРЭМСЭН, ХӨХҮҮЛ ЭХЧҮҮДИЙН КОВИД-19-ИЙН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТ

*ЭМЧ НАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ*

## ЗОРИЛГО:

Энэхүү зөвлөмж нь эмч, эрүүл мэндийн ажилтнууд жирэмсэн, хөхүүл эхчүүдэд КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтын ач холбогдол, тэдний зайлшгүй мэдвэл зохих асуудлуудын талаар зөвлөгөө мэдээлэл хүргэхэд зориулагдсан болно.

## ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

·Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ 2020) Коронавируст халдварыг SARS-CoV-2 -ээр үүсгэгдсэн КОВИД-19 цар тахал гэж зарласанаас хойш 2 жилийн хугацаанд Монгол улсад нийт батлагдсан халдврын тоо 916 мянга гаруй, нас баралт 2106 орчим (ДЭМБ, 2022.03.18) байна. Ковид-19 цар тахал нь жирэмсэн үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжинд сөргөөр нөлөөлж, эх ноцтой хүндрэх, эндэх шалтгаан болж байна. (Lancet, March 2021).

·Монгол Улсад хүн амын дархлаажуулалтын хамрагдалт зорилтот бүлгийнхэний дунд 90%-д хүрч, халдварын тархалт буурч байгаа хэдий ч жирэмсэн, төрсөн эхчүүдийн дархлаажуулалт хангалттай түвшинд хүрээгүй байна.

·Жирэмсэн, төрсөн эхчүүдийн КОВИД 19-ийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг сайжруулахад анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн зөвлөгөө өгөх ур чадвар чухал ач холбогдолтой. Иймд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгөхөд зориулсан зөвлөмж, гарын авлага шаардлагатай байна.

·ДЭМБ, Америк, Англи зэрэг хөгжсөн улс орны мэргэжлийн нийгэмлэг холбоодоос жирэмсэн, төрсөн эхчүүдэд Ковид-19-ийн эсрэг дархлаажуулалтын талаар нотолгоонд суурилсан зөвлөмж гаргасныг улс орнууд өөрийн нөхцөл байдалд тохируулан түгээж, бүхий л салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг зөвлөгөө өгөх нэгдсэн удирдамжаар хангахыг зөвлөж байна.



## **ЗӨВЛӨМЖИЙН АГУУЛГА:**

Энэхүү зөвлөмж нь жирэмсэн, хөхүүл эхчүүдийн дархлаажуулалттай холбоотой тэдний зайлшгүй мэдвэл зохих мэдээллэлүүдийг олон улсад хийгдсэн судалгааг үндэслэн нотолгоо, баримтуудад тулгуурласан болно. Түүнчлэн жирэмсэн, хөхүүл эхчүүдийн КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалттай холбоотой мэдэхийг хүсэж буй олон нийтлэг асуулт, хариултыг багтаасан болно.

### **1.ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД ҮЗЛЭГИЙН ҮЕД ӨГӨХ НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ**

1.1. КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтанд хамрагдаагүй бол үзлэг бүрт вакцин хийлгэх ашиг тусын талаар зөвлөнө.

1.2. Жирэмсэн, хөхүүл эхчүүд коронавирусын халдварт өртөх эрсдэл жирэмсэн бус эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр ба умайн гаднах жирэмсэлт, дутуу төрөлт, төрөх үеийн хүндрэл илүү тохиолдож байна. Жирэмсэн, хөхүүл эхчүүдэд КОВИД-19 дархлаажуулалт сөрөг нөлөөгүй болох нь олон эмнэлзүйн судалгаа шинжилгээгээр нотлогдсон тул ДЭМБ болон олон улсын мэргэжлийн эмч нарын холбооноос жирэмсэн, хөхүүл эхчүүдийг дархлаажуулалтанд идэвхитэй хамруулахыг чухалчлан зөвлөж байна.

1.3. ДЭМБ жирэмсэн, хөхүүл эхчүүдэд КОВИД-19-өөс сэргийлж одоо байгаа вакцинуудаас алийг нь ч хийж болохыг зөвлөсөн ч манай улсад дархлаажуулалтын анхдагч болон нэмэлт тунг Pfizer–BioNTech вакцинаар хийж байна.

1.4. КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтыг жирэмсний хугацаанаас үл хамааран хэдийд ч хийлгэж болно. Жирэмсэн, төрөлтийн хүндрэлээс сэргийлэхийн тулд аль болох эрт хийлгэх нь ач холбогдолтой.

1.5. КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтыг улирлын томуу, хөхүүл ханиад татран сахуугийн гуравт вакцин гэх мэт бусад вакцинтай хамт нэгэн зэрэг хийж болно.

1.6. Жирэмсэн, саяхан жирэмсэн байсан эмэгтэйчүүд, төрсний дараах 42 долоо хоног хүртэлх хугацаанд байгаа хөхүүл эхчүүд КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 6 сар өнгөрсөн бол бүүстер (нэмэлт) тунд хамрагдахыг зөвлөнө.

## 2. ЖИРЭМСЭН, ХӨХҮҮЛ ЭХЧҮҮДИЙГ КОВИД-19-ИЙН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРАГДАХЫГ ДЭМЖИЖ, ТЭДЭНД ВАКЦИНЫ АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААР ӨГӨХ ГОЛ МЭДЭЭЛЭЛ

### 2.1. Жирэмсэн үед КОВИД -19 -тэй холбоотой үүсэх эрсдэл, хүндрэл

2.1.1 Жирэмсэн үед эмэгтэйн бие махбодид үүсэх физиологийн өөрчлөлтүүд нь КОВИД-19 хүндрэхэд нөлөөлнө: Тухайлбал эхийн хэвлийд дэх ургийн өсөлтийг хэвийн байлгах үүднээс жирэмсэн эмэгтэйн дархлаа сулардаг, амьсгалын тогтолцоонд ачаалал үүсэж минутын амьсгалын эзэлхүүн нэмэгдэж гипервентиляци үүссэнтэй холбоотой амьсгалын шүлтшилт үүсдэг зэрэг олон үйл ажиллагааны өөрчлөлт нь уушги амархан хавагнах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Жирэмсэн үеийн дааврын нөлөөлөөр амьсгалын дээд замын салст хөөнгөтөж амьсгалын дээд замын халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн зүрх судас, цусны эргэлтийн тогтолцоонд гарах зүрхний шахалт нэмэгдэх, захын судасны эсэргүүцэл буурах, физиологийн цус багадалт, цусны бүлэгнэх тогтолцооны идэвхижил зэрэг өөрчлөлтүүд нь жирэмсний туршид зүрхний ачаалалыг нэмэгдүүлдэг. Эдгээр өөрчлөлтүүд нь өвчинд өртөмтгий байдлыг нэмэгдүүлнэ.

2.1.2 Жирэмсэн эмэгтэйчүүд КОВИД-19-өөр өвдсөн тохиолдолд өвчин хүндрэх, эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэх, зохиомол амьсгал хийгдэх шаардлага илүү тохиолдож, нас барах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Судалгаагаар КОВИД-19-өөр өвдөөгүй жирэмсэн эмэгтэйчүүдтэй харьцуулахад эхийн ноцтой хүндрэл 2,5 дахин, эрчимт эмчилгээнд эмчлэгдэх нь 5 дахин, дутуу төрөлт 2 дахин, эхийн эндэгдэл 22 дахин нэмэгдэж байгааг тогтоосон байна (JAMA Pediatr. Published online April 22, 2021. doi:10.1001/jamapediatrics.2021.1050). Монгол улсад КОВИД-19 эхийн эндэгдлийг 1.18 дахин нэмэгдүүлээд байгааг ЭХЭМҮТ- д хийгдсэн судалгааны үр дүн тогтоосон байна.

2.1.3 Жирэмсэн эмэгтэйчүүд чихрийн шижин, илүүдэл жин, таргалалт, зурх судас зэрэг суурь өвчинтэй байх нь өвчин илүү хүндэрч, дутуу төрөх, жирэмсэний хожуу хордлогоор хүндрэх, амьгүй төрөх эрсдлийг нэмэгдүүлж байна.



### 3. КОВИД-19-ИЙН ЭСРЭГ ВАКЦИНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ӨГӨХ МЭДЭЭЛЭЛҮҮД

3.1. ДЭМБ, олон улсын мэргэжлийн байгууллагууд КОВИД-19 цар тахлын үед жирэмсэн эмэгтэйд яаралтай ашиглах зөвшөөрлийг Pfizer–BioNTech, Moderna, Astra Zeneca, Janssen, Sinopharm, Sinovac-CoronaVac зэрэг хэд, хэдэн төрлийн вакцинд олгосон (ДЭМБ 2022. 02.15).

3.2. Монгол Улсад ЭМС-ын 2021 оны 05 сарын 28-ны А/338 тоот тушаалын дагуу жирэмсэн эмэгтэйчүүдэд КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтанд Pfizer–BioNTech вакцинаар дархаажуултыг хийхээр зөвлөсөн.

3.3. Жирэмсэн, хөхүүл эхчүүдэд хийсэн олон судалгаагаар КОВИД-19-ийн аль ч вакцин эх болон урагт сөрөг нөлөөгүй болох нь тогтоогдсон байна. Тухайлбал 131103 жирэмсэн эмэгтэйчүүдийг хамруулсан 5 улс улсын 14 судалгаагаар зулбалт, дутуу төрөлт, амьгүй төрөлт, төрөлтийн хүндрэл, ургийн хөгжлийн гажиг үүсэх г.м хүндрэл тохиолдоогүй байна<sup>2</sup>

3.4. Жирэмсэн эмэгтэйчүүдэд вакцин хийлгэсний дараа илрэх шинж тэмдгүүд нь жирэмсэн биш эмэгтэйчүүдтэй адил байна. Вакцины дараа 2-3 хоногт тарисан газар хөндүүрлэх, бага зэрэг халуурах, булчин өвдөх, толгой өвдөх, ядрах зэрэг шинжүүд илэрнэ. Эдгээр шинжүүд нь таны бие махбодид вакцины эсрэг хариу урвал үзүүлж дархлаа тогтож буйг илтгэнэ. Шаардлагтай бол парацетамол, аспирин зэрэг эмүүдийг ууж болох ба сайн унтаж амрах хэрэгтэй.



## 4. КОВИД-19-ЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

4.1. Эмнэлзүйн судалгааны үр дүнгээс харахад жирэмсэн болон жирэмсэн биш эмэгтэйчүүдэд дархлаажуулалтын үр дүн ижил байна. Nature medicine<sup>6</sup> сэтгүүлд хэвлэгдсэн судалгаагаар жирэмсэн эмэгтэйчүүдэд хийгдсэн Pfizer-BioNTech COVID-19 вакцины үр дүн эхний тунгийн дараа 71-94%, хоёрдах тунгийн дараа 96% гэж тогтоожээ. Вакцин хийсний дараа КОВИД -19-өөр өвдөж болох ч өвчин хүндрэх, эрчимт эмчилгээнд орох, нас барахаас сэргийлнэ.

4.2. КОВИД-19-өөр эндсэн эхчүүдийн дийлэнх нь дархлаажуулалтанд хамрагдаагүй байсан<sup>3</sup>.

1.3. Израйлд хийгдсэн вакцины бүүстер буюу дархлаа сэргээх тунгийн үр нөлөөний судалгаанд хамрагдсан 198,476 хүнээс бүрэн тунд хамрагдсан 4588, бүүстер тунд хамрагдсан 7442 нь жирэмсэн эхчүүд байжээ. Судалгааны үр дүнгээр дархлаа сэргээх тун хийгдсэн хүмүүсийг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээс 93%, өвчний хүндрэлээс 92%, нас баралтаас 81% хамгаалж байгаа нь тогтоогдсон.

4.4. ХӨСҮТ-ийн судлагаагаар Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтын дараах дархлаа нь халдвараас 70-72%, өвчний хүндрэл болон нас баралтаас 90-92% сэргийлж байна. Дархлаа тогтоц нь хугацааны хамааралтай буурч байна. Бүүстер буюу 3 дахь тун нь Ковид-19 халдварын эсрэг дархлааны хариу урвалыг сэдээж байгааг тогтоожээ<sup>4</sup>.

4.5. ДЭМБ, CDC болон олон улсын байгууллагууд бүгд жирэмсэн, хөхүүл эхчүүдийг бүүстер тунд хамрагдахыг зөвлөж байна.

4.6. Жирэмсэн, хөхүүл эхчүүд вакцины эхний тунд хамрагдсанас хойш 6 сар болсон, эсвэл жирэмсэн болохоос өмнө дархлаажуулалтанд хамрагдаад 6 сар болсон бол бүүстер тунг урд нь хийлгэсэн ижил төрлийн вакцинаар хийлгэхийг зөвлөнө.

4.7. КОВИД-19 -ийн дархлаажуулалтын бүрэн тун болон цуврал тунг авсан жирэмсэн, төрсний дараа 6 долоо хоног хүртэл хугацаатай эхчүүдэд дархлаа идэвхижүүлэх тунг Pfizer-BioNTech вакцинаар хийлгэхийг зөвлөнө.

Жирэмслэхээс өмнө бүрэн тунд хамрагдсан жирэмсэн, төрсний дараа 6 долоо хоног хүртэл хугацаатай эхчүүдэд мөн эдгээр зөвлөмжийг баримтална.

## 5. КОВИД-19-ИЙН ДАРХЛААЖУУЛАЛТ НЯРАЙД НӨЛӨӨЛӨХ НЬ

5.1. Вакцин хийлгэсэн эхчүүдээс төрсөн нярайн цусанд IgG эсрэг бие илэрч байгааг ажиглалт судалгаагаар тогтоосон. Вакцин хийлгэхэд ихсээр урагт IgG эсрэг бие дамжиж нярайг төрсний дараах эхний саруудад халдвараас хамгаалдаг болох нь судалгаагаар тогтоогдсон.

5.2. Дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан эмэгтэйчүүдэд вакцин хийлгэсэн хугацаанаас үл хамаарч нярайд дамжуулах эсрэг биеийн түвшин өндөр байна. Жирэмсний 3 дахь 3 сард бүүстэр тун хийлгэсэн эхчүүдийн нярайн хүйн цусанд эсрэг биеийн хэмжээ хамгийн өндөр байжээ.

5.3. Нярай, бага насны хүүхдэд вакцин хийх талаар одоогоор удирдамж байхгүй байна.




## 6. БАРИМТЖУУЛАЛТ

6.1. Жирэмсэн, хөхүүл эхчүүдэд КОВИД-19 дархлаажуулалтын талаар зөвлөгөө өгснийг жирэмсэний хяналтын хөтөч-д тэмдэглэж, баримтжуулна. Дараагийн үзлэгт ирэх үед жирэмсэн эмэгтэй дархлаажуулалтанд хамрагдаагүй байвал дахин зөвлөгөө өгч, жирэмсэний хөтөч-д тэмдэглэл хөтөлнө.

## 7. ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨГӨӨ

7.1. Эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүд халдвараас сэргийлэх бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар жирэмсэний үзлэг болгонд тогтмол зөвлөнө. Үүнд:

- Гараа тогтмол угааж, ариутгалын уусмал хэрэглэх
  - Хүн хоорондын зай барих
  - Олон хүн цугларсан газарт очихгүй байх
  - Амны хаалт тогтмол зүүх
- Өрөө тасалгаандаа агааржуулалтыг тогтмол хийж байх





## 8. АСУУЛТ ХАРИУЛТ

Эдгээр асуулт, хариулт нь ДЭМБ-ын хамгийн сүүлийн түр удирдамж болон ЭМЯ-ны гаргаж буй зөвлөмжүүдэд үндэслэсэн болно.

### 8.1. Жирэмсэн, төрсөн эхчүүд дархлаажуулалтанд заавал хамрагдах хэрэгтэй юу?

8.1.1. **Хэрэгтэй.** Вакцин нь Ковид-19-ийн хүндрэл, дутуу төрөлтөөс сэргийлэх, эрсдлийг бууруулах ач холбогдолтой тул эмэгтэйчүүд аль болох жирэмсний эрт хугацаанд дархлаажуулалтанд хамрагдах хэрэгтэй.

### 8.2. Ковид-19 -ийн дархлаажуулалт хэр зэрэг үр дүнтэй вэ?

8.2.1. **Үр дүнтэй.** Вакцин нь Коронавирусын халдварт өртөхөөс сэргийлэхээс гадна өвчилсөн тохиолдолд хүндрэх, эмнэлэгт хэвтэх, эрчимт эмчилгээнд эмчлүүлэх, нас барах эрсдлийг бууруулна. Эмнэлзүйн судалгаануудаас үзэхэд жирэмсэн эмэгтэйчүүдэд хийж буй Pfizer BioTech өндөр үр дүнтэй вакцин юм.

8.2.2. АНУ-д 198000, Англид 100,000, Бразилд 1сая гаруй вакцинд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийг бүртгэж судлахад жирэмсэний явц, төрөлтийн үр дүн нийт жирэмсэн эмэгтэйчүүдтэй харьцуулахад ижил үр дүнтэйгээс гадна аюулгүй болох нь нотлогдсон.

### 8.3. Ковид-19 -ийн вакцин нь халдвараас яаж хамгаалдаг юм бэ? Миний тээж буй хүүхдэд нөлөө үзүүлэх үү?

8.3.1. Ковид-19 -ийн үед хэрэглэх бүх вакцин амьд вирус агуулаагүй учраас танд болон таны хүүхдэд ямар нэгэн **эрсдэл үүсгэхгүй.**

8.3.2. Эдгээр вакцин нь жирэмсэн үед бусад өвчнөөс сэргийлэх зорилгоор хийгддэг вакцины нэгэн адил арга, технологиор бүтээгдсэн. Тухайлбал: жирэмсэн үед хийгддэг ХДХВ, Эболагийн вакцинтай адил технологиор Астра Зеника хийгдсэн бол Хятадад үйлдвэрлэгдсэн Синофарм нь ердийн уламжлалт вакцин тухайлбал гепатит В вирус болон сахуу татрангийн вакцины технологитой адил хийгдсэн байна.

## **8.4. Жирэмслэхээр төлөвлөж байгаа бол вакцин хийлгэх шаардлагатай юу?**

8.4.1. **Шаардлагатай.** Харин ч жирэмслэхээс өмнө дархлаажуулалтанд хамрагдсанаар жирэмсэн үедээ халдварт өртөх, хүндээр өвдөх эрсдлээс сэргийлнэ. Ингэснээр та хүүхдээ хүндрэлгүй тээх боломжтой.

8.4.2. Одоог хүртэл хийгдсэн олон судалгаанд КОВИД-19-ийн вакцин жирэмслэх чадварт нөлөөгүй болохыг тогтоосон.

8.4.3. ДЭМБ болон олон улсын мэргэжлийн холбоодоос гаргасан зөвлөмжүүдэд вакцин хийлгэснээс болж жирэмслэх төлөвлөгөө, эсвэл жирэмсэлтийг таслах шаардлагагүй гэдгийг тодорхой заасан байна.

## **8.5. Төрснөөс хойш хэдий хугацааны дараа вакцинд хамрагдах вэ, Хөхний сүүгээр халдвар дамжих уу?**

8.5.1. Төрсний дараах 42 хоногийн дотор болон цаашид аль ч хугацаанд вакцин хийлгэж болно. Хөхүүл эхчүүд вакцин хийлгэсний дараа хүүхдээ хөхүүлэхээ зогсоох шаардлагагүй, үргэлжүүлэн хөхүүлж болно (ACOG, 2021).

8.5.2. Жирэмсэн үедээ вакцины бүрэн тунд хамрагдаад сүүлийн тунгаас хойш 6 сар болсон хөхүүл эхчүүд бүүстер тунд хамрагдана.

8.6. КОВИД-19 -өөр өвдөөд эдгэрсэн бол вакцин хийлгэх шаардлагатай юу?

8.6.1. ЭМЯ-ны гаргасан зааврын дагуу эдгэснээс хойш 3 сарын дараа дархлаажуулалтанд хамрагдахыг зөвлөж байна.

## **8.7. КОВИД -19-ийн вакцин цусыг өтгөрүүлдэг үү?**

8.7.1. Судлагаагаар цөөн тохиолдол бүртгэгдсэн гэхдээ жирэмсэн эмэгтэйчүүдэд ийм тохиолдол бүртгэгдээгүй байна.

8.7.2. Вакцин хийлгэхээс өмнө жирэмсэний хяналтын эмчид үзүүлж зөвөлгөө авч жирэмсэн эхэд эрүүл мэндийн талаас вакцин хийхэд харшлах зүйл байгаа эсэхийг тодруулах хэрэгтэй.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Trostle ME, Limaye MA, Avtushka V, Lighter JL, Penfield CA, Roman AS. COVID-19 vaccination in pregnancy: early experience from a single institution. Am J Obstet Gynecol MFM 2021 Aug 16;3(6):100464.
2. COVID-19 vaccine information from the Royal College of Obstetricians and Gynaecologists: fal.cn/3j0a9
3. Эхийн эндэгдлийн судалгаа 2021
4. Г.Цогзолмаа "КОВИД-19 халдварын эсрэг дархлаажуулалт: II тун болон сэргээх III тун, ХӨСҮТ, 2021 он 10 сар
5. Shimabukuro TT, Kim SY, Myers TR, Moro PL, Oduyebo T, Panagiotakopoulos L, et al. Preliminary Findings of mRNA Covid-19 Vaccine Safety in Pregnant Persons. The New England journal of medicine 2021 Jun 17;384(24):2273-82.
6. Nature medicine, Effectiveness of the BNT162b2 mRNA COVID-19 vaccine in pregnancy, <https://www.nature.com/articles/s41591-021-01490-8>
7. Schaler L, Wingfield M. COVID-19 vaccine - can it affect fertility? Ir J Med Sci 2021 Oct 15. <https://www.ncbi.nlm.nih.gov/pubmed/34496196>





Coronavirus  
**COVID-19**  
**Vaccine**

Injection Only